



## Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны эхний хагас жилийн хийсэн ажлын бичмэл тайлан

### ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

#### ХҮНИЙ НӨӨЦ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Тус хэлтэс нь 2022 онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны А/22 дугаар тушаалаар 4 тасаг 47 орон тоотой батлагдсан бүтэц зохион байгуулалтаар ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар орон тооны гүйцэтгэл 39 байна.

НДЕГ-ын даргын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны “Аймгийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтыг бүтэц, орон тоог шинэчилэн батлах тухай” А/51 дүгээр тушаал ирсэн бөгөөд албан тушаалын тодорхойлолт шинэчилэгдэн ирээгүй байгаа тул бүтэцэд өөрчлөлт ороогүй байна.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, удирдлага, хяналтын тогтолцоог үр ашигтай, оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээний чанартай, хүртээмжтэй, шуурхай, нээлттэй, ил тод байдлыг хангах зорилт тавин ажиллаа.

Төрийн албаны шалгалтад тэнцэж, нөөцөд бүртгэгдсэн иргэн байхгүйн улмаас өндөр насны тэтгэвэр, жирэмсэн, амаржсан, хүүхдээ асрах чөлөө авсан ажилтны сул орон тоог (ялангуяа сумдад) нөхөхөд хүндрэл үүсэж, төрийн албаны тасралтгүй, шуурхай байдлыг алдагдуулж байна. Тайлант хугацаанд Норовлин, Баян-овоо, Гурванбаян, Галшар, Дархан сумын нийгмийн даатгалын байцаагч, Сургалт сурталчилгаа сүлжээ хариуцсан мэргэжилтэн, Бор-Өндөр сумын НДТасгийн байцаагч, нийгмийн хамгааллын улсын байцаагч гэсэн албан тушаалын сул орон тоо гарч зохих хууль, тогтоомжийн дагуу аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлсэн боловч нөөцөд шаардлага хангасан ажилтан байхгүй байна.

№	Албан тушаалын ангилал	төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Удирдах албан тушаалтан	1	1
2	Гүйцэтгэх албан тушаалтан	41	33
3	Үйлчилгээний	5	5
<b>Нийт</b>		<b>47</b>	<b>39</b>

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд 2024 онд 1484.5 сая төгрөг батлагдсан. Батлагдсан төсвийн 337,2 сая төгрөгийг цалин хөлсөнд, нийгмийн даатгалын шимтгэлд 39,10 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 18,3 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 2,6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 0,7 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 1,0 сая төгрөг, томилолтын зардалд 2,7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 0,5 сая төгрөг, ЭХМК-н зардалд 25,3 сая төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулалд 4,6 сая төгрөг, Хөдөө орон нутагт тогтвор сууршилтай ажилсан тэтгэмж 109,3 сая төгрөг, ажил олгогчоос олгох тэт, урамтус 1,0 сая төгрөг тус тус эдийн засгийн ангилал зориулалтаар батлагдсан төсвийн хүрээнд зарцуулан ажиллаа.

➤ *Хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам зааврын дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул Аймгийн Аудитын газраас **ЗӨРЧИЛГҮЙ** дүгнэлт авсан.*

## ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хэлтсийн даргын А/01 тоот тушаалаар батлагдсан хэлтэс болон сумдын 2023 оны архивын баримт тушаах хуваарийн дагуу хүлээн авч хяналт шалгалтын байцаагчаар баталгаажуулан архивын нэгж үүсгэлээ. 2023 оны архивын 211 ширхэг баримт бичгийг хэлтэс болон сумдын байцаагч, ажилтнуудаас хуулийн хугацаанд хүлээн авч, түр хадгалах, байнга хадгалах гэсэн төрлөөр ангилан, хадгаламжийн нэгж бүрдүүлэн байгууллагын архивыг цэгцлэн ажилласан. Мөн 78 нас барьсан болон зогсоогдсон тэтгэврийн хувийн хэргийг сумдаас хүлээн авч архивын нэгж болгон хадгалсан. “Нийгмийн даатгал” гар утасны аппликейшн, E-Mongolia системийг иргэдэд сурталчлан мөн үйлчилгээний чанарыг сайжруулж цар тахалын үед даатгуулагчдыг өөрийн биеэр ирүүлэхгүйгээр нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг олгох, хэлтсүүд хооронд шимтгэл төлөлтийн лавлагааг цахимаар солилцох ажлыг хэвшил болгон ажиллаж байна. Иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлт болон нөхөн даатгалын лавлагааны хүсэлтийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс able программ, албаны имэйлээр хүлээн авч хариуг ажлын 3 хоногийн дотор гарган өгч хэвшээд байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар тус хэлтэст 226 иргэнээс лавлагааны хүсэлт ирж, 240 иргэн, байгууллагад нийгмийн даатгалын төрөлжсөн архивын лавлагааг олгосон байна. Мөн архивт хадгалагдаж байгаа зогсоогдсон тэтгэврийн хувийн хэргийг цэгцэлж, хадгалах хугацаа дууссан хувийн хэргийг ялган дугаарыг шинэчилэн хамгаалалтын хайрцагт хийн сан хөмрөгт зааврын дагуу байршуулан ажиллаж байна.

Сар бүрийн хүний нөөцийн тайланг Green программаас хөрвүүлж НДЕГ-ТГазарт хүргүүлэн ажиллаж байна. Хагас жилийн байдлаар хүний нөөцтэй холбоотой 32 төрлийн судалгааг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн программд ажиллагсадын мэдээллийг дахин тулгаж, үнэн зөв баазыг бүрдүүлсэн. Мөн зэрэг дэв ахиулах 18, шинээр авах 2 байцаагчийн материалыг бэлтгэн хүргүүлж, захирамж гаргуулсан. Шинээр томилогдсон, чөлөөлөгдсөн зэрэг албан хаагчтай холбоотой Б тушаалын төслийг боловсруулж эрх бүхий албан хаагчаар баталгаажуулан ажиллаж байна. Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоог тухай бүр нийтэд зарлаж 2 сул орон тоог нөхсөн.

2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын талаарх сургалтыг 40 нэгжид 1856 даатгуулагч хамруулан хийсэн. Мөн албан хаагчдад хуулийн шинэчилэлийн хүрээнд хуулийг хэрэгжүүлэхээр гаргасан 53 дүрэм, журам, зааварыг танилцуулж, арга зүйн зөвлөгөө өгч өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллаж байна. Мөн дээд газраас ирүүлсэн хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд шаардлагатай заавар, чиглэлийг төвийн болон сумдын байцаагч нарт тухай бүр танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 20-ны 120 тогтоолоор 2024 оны 04 дүгээр сарын 01-нээс Нийгмийн даатгалын сангаас болон цэргийн тэтгэвэр авагч нийт 13610 даатгуулагчийн тэтгэврийн хэмжээг 100,000 (нэг зуун мянга) төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн батлагдсан төсвийн хүрээнд олгох ажлыг хийж гүйцэтгэсэн.

“Ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд чиглэсэн сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээ” үзүүлэх зорилтын хүрээнд зохион байгуулж байгаа **CallPro Teams** үйлчилгээг нэвтрүүлж 70562212 дугаарыг “**CallPro**” үйлчилгээнд холбон шаардлагатай байцаагч, албан хаагчийн албан тушаал, дугаарыг оруулан өгснөөр утасны дуудлага бүрт хариу өгч, иргэд даатгуулагчдад мэдээлэл, зөвлөгөөг өгч ажиллаж байна.

Хэнтий аймгийн ЗДТГазраас төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр Хэнтий аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын дунд “АСУУДЛААС – ШИЙДЭЛД” болзолт уралдааныг 3 үе шаттайгаар зохион байгуулж байна. Тус уралдаанд манай байгууллага идэвхтэй оролцож 1 албан хаагчийг сонгож нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр 3.4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг үзүүлж ажилласан. Мөн төрийн үйлчилгээг ажил олгогч, иргэд даатгуулагчдад түргэн шуурхай хүргэх, ажлаа сайжруулах саналыг газрын болон сумдын байцаагч нараас авч нэгтгэн эрэмбэлэж хамт олны 100 хувийн саналаар үйлчилгээний заалны орчин, тохижилтыг сайжруулах, архивын баримтыг эмхэлж цэгцлэх ажлыг сонгон хийж гүйцэтгэж байна. Тэмцээны эхний шатны шалгаруулалтанд 10 байранд шалгарсан.

Архивт хадгалагдаж байгаа зогсоогдсон хувийн хэрэг цэгцлэв



Үйлчилгээний зааланд урсгал засвар хийж эхлээд байна.





## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО

2024 оны хагас жилийн сангийн орлогын төлөвлөгөө **25,745.6** сая төгрөгөөр батлагдсанаас нийгмийн даатгалын сангийн орлого **25,838.6** сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу төлөвлөгөөг **100.3** хувиар биелүүлсэн.

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 1-6 сард 83.2-101.0 хувиар биелүүлэн ажиллаа. Сар бүрийн төлөвлөгөө тасарсан шалтгаан нь эхнээс Бор-Өндөрийн Монросцветмет Уулын баяжуулах үйлдвэр нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрөө төлөхгүй сар бүр 1,350.0 сая төгрөгийн өр үүсгэснээс орлогын төлөвлөгөө жигд биелэхгүй байсан.

Нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй аж ахуйн нэгж байгууллага, иргэнийг хамруулах, хуримтлагдсан авлагыг барагдуулах ажлуудыг зохион байгуулсны үр дүнд ажил олгогч **972**, заавал даатгуулагч **14276** болж, оны эхнээс шинээр **43** ажил олгогч, **101** даатгуулагчийг бүртгэн, шимтгэл тооцох цалингийн сан **67.0** сая төгрөгөөр нэмэгдсэн.

### Нийгмийн даатгалын сангийн орлого сан тус бүрээр

Сан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь
Тэтгэврийн даатгалын сан	21,444.3	21,652.3	101.0
Тэтгэмжийн даатгалын сан	2,139.5	2,257.4	105.5
ҮОМШӨ-ний даатгалын сан	1,389.5	1,512.2	108.8
Ажилгүйдлийн даатгалын сан	772.3	416.7	53.9
<b>НИЙТ</b>	<b>25,745.6</b>	<b>25,838.6</b>	<b>100.3</b>

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА

Нийгмийн даатгалын сангийн батлагдсан төлөвлөгөө **61,279.7** сая төгрөгөөс **55,721.7** сая төгрөгийн зарлагыг батлагдсан төсөвт багтаан сан тус бүрээр зориулалтын дагуу хэтрүүлэлгүй ажилласан. Нийт зардлын **91.0** хувийг тэтгэврийн даатгалын сан эзэлж байна. 2024 оны хагас жилийн байдлаар давхардсан тоогоор **89** гаруй мянган даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хуульд заасан хугацаанд нь тогтоон бүрэн олгож, тэтгэвэр авагч, даатгуулагч иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээг жигд, хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэлээ.

### Нийгмийн даатгалын сангийн зарлага сан тус бүрээр

Сан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь	Хэтрэлт - Хэмнэлт+
Тэтгэврийн даатгалын сан	54,826.2	50,726.7	92.5	+4,099.5
Тэтгэмжийн даатгалын сан	2,963.4	2,149.5	72.5	+813.9
ҮОМШӨ-ний даатгалын сан	2,667.0	2,190.0	82.1	+477.0
Ажилгүйдлийн даатгалын сан	822.9	655.5	79.6	+167.4
<b>НИЙТ</b>	<b>61,279.5</b>	<b>55,721.7</b>	<b>90.9</b>	<b>+5,557.8</b>


### НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХАМРАГДАЛТ

Аймгийн хэмжээнд нийгмийн даатгалын мэдээллийн санд 2024 оны хагас жилийн байдлаар нийт **982** төсвийн болон аж ахуйн нэгж, байгууллага бүртгэгдсэн нь эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагын **85** хувийг эзэлж байна. Мөн албан журмын болон сайн дурын даатгалд 19.2 мянган даатгуулагч хамрагдсан нь эдийн засгийн идэвхтэй хүн амын **49,3** хувийг эзэлж байна.

Тайлант хугацаанд шинээр **43** ажил олгогч хамруулсан ба албан журмын **101** даатгуулагчийг нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгэн нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан тооцоог хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулан ажиллаа.

Аймгийн хэмжээнд нийт **4969** даатгуулагч сайн дурын даатгалд хамрагдсанаас шинээр 835 даатгуулагч хамрагдсан. Үүнээс: малчин 2286, шинээр 486 малчин хамрагдсан байна.

### Нийгмийн даатгалын хамралт



### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН АВЛАГА

2023 оны жилийн эцсээр нийгмийн даатгалын шимтгэлийн авлага нийт **2,980.7** сая төгрөг байснаас хагас байдлаар нийт авлагын **91.0%** буюу **2,712.4** сая

төгрөгийг барагдуулсан. 2023 оны эцсийн авлагаас **268.2** сая төгрөгийн авлага үлдсэн бөгөөд урсгал авлага жилийн эцсээр **2,071.3** сая төгрөг байна. Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогод эзлэх хувь **9.6** байна

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлсэн:

- 14 аж ахуйн нэгжийн 302.2 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагад дансны хаалт тавьж 112.0 сая төгрөгийн татан авч, нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн.
- Нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан авлага үүсгэсэн 12 аж ахуй нэгжийн 88.6 сая төгрөгийн авлагыг Хэнтий аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжилсэн
- Хуримтлагдсан авлага үүсгэсэн Нийгмийн даатгалын тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлдэггүй төсөвт байгууллагын мэдээг Санхүү төрийн сангийн хэлтэст, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг гэрээ бүхий байгууллагуудыг Эрүүл мэндийн даатгалын хэлтэст сар бүрийн 15-нд албан бичгээр хүргүүлж, хамтран ажиллаж, өр авлага барагдуулан ажиллаж байна.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд 9 аж ахуйн нэгжийн 18.6 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй. Үүний 11,7 сая төгрөг нь Жижиг эрдэнэ ХХКомпаний өр бөгөөд тухайн өр нь давж заалдах шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэж, Нийслэлийн ШШГГ ажиллагаа хийж байх явцад хариуцагч зуурдаар нас барсан. Иргэний хуулийн дагуу өв нээх хугацаа өнгөрсөн ч тухайн нас барагчийн өвийг хүлээж аваагүй байгаа тул ажиллагаа явуулах боломжгүй болсон, Мөн Дорнод Монгол ХХКомпани 6.9 сая төгрөг нь 2000 онд шийдвэр гаргаж 2002 онд ШШГГазарт шилжсэн гүйцэтгэх ажиллагаа хийгдээгүй. Ажиллагааг дахин сэргээхээр Улсын бүртгэлийн хэлтсээс лавлагаа авахад тус компани нь татан буугдсан тул хариуцагчгүй болсон.

## ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САН



Тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байгаа **13560** тэтгэвэр авагчид **50,681.4** сая төгрөг зарцуулсан байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу хагас жилийн байдлаар тэтгэвэр шинээр тогтоолгосон 381 үүнээс ӨНТ 264, ХЧТ 98, ТАТ 19 тэтгэвэр авагч байна.

Шилжиж ирсэн нийт 5 үүнээс ӨНТ-1, ТДТ-3, ТАТ-1 тэтгэвэр авагч, шилжиж явсан нийт 35 үүнээс ӨНТ-30, ТДТ-3, ТАТ-2 тэтгэвэр авагч байна. Мөн тэтгэвэрээ өөрчлөн тогтоолгох нийт 252 хүнээс ӨНТ 104, ХЧТ-288 ТАТ-15 тэтгэвэр авагч байна.

Тэтгэвэр шинээр болон өөрчилөн тогтоолгохоор хүсэлт гаргасан мөн шилжиж ирсэн иргэдийн баримт бичгийг нягтлан шалгаж, үндэслэлийг хянан шалгаж, дараалалын дагуу мэдээллийн баазад бүртгэн тэтгэврийг үнэн зөв тогтоож, хяналтаар оруулан баталгаажуулж, зөрүү тэтгэврийн дүн үүссэн тохиолдолд тухай бүрт нь олголтыг хийж ажиллаж байна.

Тэтгэврийг хамтран ажиллах гэрээний дагуу арилжааны банкнуудаар сар бүрийн 01-нд олгож хэвшсэн.

**Хүснэгт.** Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө (сая төгрөгөөр)

Тэтгэврийн төрөл	Суурь түвшин буюу 2023 оны мөн үе		Хүрсэн түвшин буюу 2024 он	
	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө
Өндөр насны	10198	31,573.8	11170	43,515.6
Тахир дутуугийн	1483	4,058.1	1576	4,312.6
Тэжээгчээ алдсаны	564	1,578.5	555	1,553.3
Цэргийн	261	1,309.9	259	1,299.9
<b>НИЙТ</b>	<b>12506</b>	<b>38,520.3</b>	<b>13560</b>	<b>50,681.4</b>

## ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САН



Тэтгэмжийн даатгалын сангаас **2815** даатгуулагчдад **2,084** сая төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олгов. Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад **194.1** сая төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт.** Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө (сая төгрөгөөр)

Тэтгэмжийн төрөл	Суурь түвшин буюу 2023 оны мөн үе		Хүрсэн түвшин буюу 2024 он	
	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо	Зарцуулсан оны хагас жил хөрөнгө
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	2008	454.5	1912	432.7
Жирэмсний болон амаржсаны тэтгэмж	580	1,089.4	742	1,393.8
Оршуулгын тэтгэмж	173	346.0	161	322.0



<b>НИЙТ</b>	<b>2761</b>	<b>1,889.9</b>	<b>2815</b>	<b>2,084.0</b>
-------------	-------------	----------------	-------------	----------------



3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа эхчүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг өөрөө төлсөн тохиолдолд үлдсэн 50 хувийг даатгуулсан эсэхээс хамаарч тэтгэмжийн даатгалын сангаас эсхүл улсын төсвөөс олгохоор шийдвэрлэсэн хуулийн хүрээнд 876 эхчүүдтэй гэрээ байгуулж тэтгэмжийн даатгалын сангаас 244.0 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангийн орлогод төвлөрүүлэн ажиллаа.

### ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САН



ҮОМШӨ-ний даатгалын сангаас **584** тэтгэвэр, тэтгэмж авагчдад нийт **2,189.2** сая төгрөгийг зарцуулсан байна.

**Хүснэгт.** Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө (сая төгрөгөөр)

Зардлын төрөл	Суурь түвшин буюу 2023 оны мөн үе		Хүрсэн түвшин буюу 2024 он	
	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө
ҮОМШӨ-ний тэтгэвэр	409	2934,2	291	2,092.9
ҮОМШӨ-ний тэтгэмж, төлбөр	67	59,7	33	29.6
Тахир дутуу иргэдийн тэтгэврийн даатгалын шимтгэл	388	99.7	260	66.7
<b>НИЙТ</b>	<b>867</b>	<b>3,212.5</b>	<b>584</b>	<b>2,189.2</b>

### АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САН



Ажилгүйдлийн даатгалын сангаас **252** даатгуулагчид ажлаас халагдсаны тэтгэмжид **655.4** сая төгрөг зарцуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.4 сая төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт.** Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө (сая төгрөгөөр)

Зардлын төрөл	Суурь түвшин буюу 2023 оны мөн үе		Хүрсэн түвшин буюу 2023 он	
	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө
Ажилгүйдлийн тэтгэмж	<b>241</b>	<b>627.0</b>	<b>252</b>	<b>655.4</b>

## ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Нийгмийн даатгалын хэлтсийн хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь Нийгмийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, дүрэм, журамд заасан эрх үүргийн хүрээнд хяналт шалгалт хийх, аливаа хууль бус үйлдлийг таслан зогсоох, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, зөрчил давтан гарахаас урьдчилан сэргийлэх, дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүргийн хүрээнд ажиллаа.

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2024 онд хийх хяналт, шалгалтын төлөвлөгөөг газрын даргаар батлуулан нийгмийн даатгалын тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар чиглэлийн дагуу дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг удирдамжид заасан хугацаанд хийж гүйцэтгэн тайлан мэдээг хүргүүлдэг. 2024 дотоодын хяналт шалгалтаар тавигдсан төлбөр зөрчлийн эхний үлдэгдэл 30.9 сая төгрөг байсан ба үүнээс эхний хагас жилийн байдлаар 2.2 сая төгрөгийг барагдуулсан байна.

Хил хамгаалах ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичгийн дагуу Хэнтий аймгийн Дадал сумын хилийн цэргийн 0287 дугаар ангитай байгуулсан санамж бичгийн хүрээнд 1997-2023 оны хооронд тус ангид алба хаасан хугацаат цэргийн албан хаагч, цэргийн албан хаагчийн ар гэр, хүүхэд асрах чөлөөтэй байсан даатгуулагч гэх мэт тухайн онуудын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд орхигдож тайлагнасан байсан 115 алба хаагч, энгийнээр ажиллаж байсан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг холбогдох баримтанд үндэслэн шалгаж улсын байцаагчийн акт үйлдэн 5.2 сая төгрөгийг төлүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн 2024 онд тус хилийн цэргийн ангитай хамтран даатгуулагчийн төрөл, үндсэн мэдээлэл засах, цалин түүнтэй адилтгах орлогод засвар хийх ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

## **БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дугаар заалтын дагуу 48 мэдээллийг вебсайт хуусанд бүрэн байршуулах ажил системын хэмжээнд хангалтгүй үнэлэгдсэн. Засгийн газраас байгууллагын нээлттэй мэдээллийг үнэн зөв, ил тод байршуулсан эсэхэд хяналт тавьж, үнэлгээ өгөх Shilen.gov.mn цахим хуудсыг нэвтрүүлсэн байна. Тус хэлтэс нь дээрх цахим хуудсанд мэдээлэл байршуулан, хяналт тавин ажиллах албан хаагчийг тушаалаар томилон хуулийн хэрэгжилтыг ханган ажиллаж байна. Мөн хяналт тавин ажиллах чиг үүрэг бүхий албан хаагчийг томилон хуулийн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Удирдлагын зүгээс Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн холбогдох зүйл заалтад заасан мэдээллийг Shilen.gov.mn, аймгийн албан ёсны вэб сайт [www.khentii.mn](http://www.khentii.mn), нийгмийн даатгалын газрын веб сайтад хуулийн хугацаанд байршуулах, хийсэн ажлын тайланг холбогдох газарт хүргүүлэхийг цахим хуудсанд мэдээлэл байршуулан ажиллах албан хаагчид чиглэл өгөн ажиллаа.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдөр баталсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийх удирдамжийн дагуу Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2024 оны 01 дүгээр сарын 03-05-ны өдрийн хооронд дотоод аудитын ажлыг зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, шилэн дансны цахим хуудасны 2023 оны хөтлөлт, тайлан мэдээ байршуулсан байдал, холбогдох шийдвэрийн хуулбар, баримт бичгийг оруулсан эсэхэд үнэлгээ өгч, гарсан зөрчлийг давтан гаргахгүй байх чиглэл өгч ажилласан. Мөн 2024 онд НДЕГ-аас ирүүлсэн чиглэл, “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, мэдээллийн үнэн зөв, бүрэн байршуулсан эсэхэд хяналт тавих ажлыг Санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтэстэй хамтран хийж гүйцэтгэж байна.

## **ЦАХИМ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР**

Нийгмийн даатгалын салбарын “Цахим хяналтын веб програм”-д тулгуурлан хяналт, шалгалтыг 2023 оныг дуустал хугацаанд сар бүр тогтмол хийж ажилласан. Цахим хяналтын программаар шүүгдэж байгаа нийт алдааны 70 орчим хувь нь зөрчлийн шинжгүй алдаа байгаа бөгөөд шийдвэрлэх боломжтой алдааг анхан шатны баримтанд тулгуурлан тухай бүр Санхүү бүртгэлийн тасаг, Үйлчилгээний тасагтай хамтран залруулан ажилласан. 2024 оны 01 дүгээр сараас эхлэн нийгмийн даатгалын мэдээллийн бааз шинэчлэгдэн вэб программд шилжсэнээр цахим хяналтын цэс ажилд ороогүй байна. 2023 оны эцэст цахим хяналтын

программаас шүүгдсэн алдаатай мэдээллийн үлдэгдэл 1385 алдааг 2024 оны тайлант хугацаанд хянан шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж ажиллана.

### **НИЙГЭМ ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР**

Тус газрын хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь 2024 оны эхний хагас жилд Нийгмийн хамгааллын байцаагчгүйгээр үйл ажиллагаа явуулсан бөгөөд нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод хяналт шалгалтыг хийгээгүй болно.

Монгол улсын засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 420 дугаар тогтоолоор баталсан “Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөө”-ний дагуу Салбарын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 13-07/08 тоот дугаартай “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан. Шалгалтаар тус газрийн 2021-2023 оны Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн орлого, зарлагын анхан шатны баримтын бүрдэл, хөдөлмөрийн чадвар алдасны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголтын материалын бүрдлийг мэдээллийн баазтай тулган шалгасан. Шалгалтанд ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр авагч 376 хувийн хэрэг, өмнөх онуудад зогсоогдсон болон нас барсан даатгуулагчийн тэтгэврийн хувийн хэрэг хамрагдсан. Шалгалтаар илэрсэн төлбөр зөрчилийн дүн эцсийн байдлаар шийдвэрлэгдэн ирээгүй байна

### **ДОТООДЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД**

Дотоодын хяналт, шалгалтын тайланг улирал бүр үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулах, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тухай бүр тооцон тайлан, мэдээг заасан хугацаанд Хяналт шалгалтын газарт хүргүүлэн ажиллаж байна.

2024 оны эхний хагас жилийн байдлаар шинээр 381 тэтгэвэр тогтоогдсон. Үүнээс өндөр насны 264, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр 98, тэжээгчээ алдсаны 19 тэтгэвэр тогтоогдож хянагдсан байна. Мөн шилжиж ирсэн 5 тэтгэвэр, шилжиж явсан 35 тэтгэврийг баазад оруулж мэдээллийн баазын бүрдлийг ханган ажилласан байна. Шүүхийн шийдвэр болон улсын байцаагчийн актын дагуу суутгал хийгдэж байгаа 12 тэтгэврийг сар бүр суутгал хийн холбогдох дансанд шилжүүлж байна. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа сунгасан, жилийн нэмэгдэл хийлгэсэн 252 тэтгэвэр авагчийн мэдээллийг хянан баталгаажуулсан. Тэтгэвэр

авах эрхийн харилцаа дууссан нас барсан, зогсоогдсон 517 тэтгэвэр авагчийн олголтын тооцоог хийж хувийн хэргийг хянан архивт шилжүүлсэн байна.

## **МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ**

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Маргаан Хянан Шийдвэрлэх Салбар Зөвлөл нь 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. 2024 оны эхний хагас жилд нийт 7 даатгуулагчийн өргөдөлийн дагуу 3 удаа хуралдаж 5 даатгуулагчид нөхцөл хангасан шийдвэр, 2 даатгуулагчийн малчин жил тогтоолгох өргөдөлийг буцааж дахин баримт бүрдүүлэх шийдвэр гаргасан байна.

## **ЭРҮҮЛ МЭНДИЙН МАГАДЛАЛЫН ЗӨВЛӨЛ.**

Хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд эрүүл мэндийн үзүүлэлттэй харьцуулан дүн шинжилгээ хийхэд өмнөх жилийнхээс өвчлөл ихэссэн байна. Эхний хагас жилийн байдлаар 46 удаа хуралдаж, 2261 иргэд даатгуулагчийн асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд үүнээс шинээр 116, хяналт үзлэг дутуу 65 иргэнийг буцааж дахин үзлэг шинжилгээнд хамруулж мөн 118 иргэнийг Эрт илрүүлэг үзлэгт хамруулсан.

ЭММЗөвлөлийн хурлаар дотоод үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж 2071 иргэний картанд хяналт шалгалт хийсэн. Иргэдийн картанд үзлэг, шинжилгээ, хяналт дутуу гэсэн зөрчилтэй 68 иргэнийг илрүүлж дутуу үзлэг, хяналт шинжилгээнд буцаасан ба дахин шалгах шаардлагатай 10 иргэнийг өөрийн биеэр дараагийн хуралд ирүүлж асуудлыг шийдвэрлэсэн. Мөн эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн цахим санд 1 удаа тулгалт хийж зөрчил дутагдалыг арилган ажиллаа. Улаанбаатарын харяатай 2 иргэнийг Баянзүрх дүүрэг, налайх дүүрэгт шилжүүлсэн.

ЭММТЗөвлөлөөс 2024 онд даатгуулагч, хүний ХЧАлдалтын хувь хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсалтын дагуу мэргэжлын багаас бүрдсэн эмч нарын сургалтыг цахимаар 6 удаа хийж сургалтанд хурлын 5 эмч 3 мэргэжилтэн 6 удаа оролцсон зэргээр мэргэжилтнүүдийн мэдлэгийг сайжруулах тал дээр анхаарч ажилласан. Бүх сумдын эрхлэгч болон эмч нарт аймгийн ЭМГазартай хамтран 40 эмч мэргэжилтэнүүд сургалт зохион байгуулсан.

ХБИргэдийн асуудал шийдвэрлүүлэх зүүн бүсийн уулзалтанд оролцож “Хэнтий аймгийн ХБИргэдийн өнөөгийн байдал”-ын талаар төрийн болон төрийн бус байгууллагын удирдлага, ХБИргэдийн 48 иргэдийн төлөөлөлд мэдээллийг хүргэсэн.

Хөдөлмөрийн аюулгүй байдлын сарын аяны хугацаанд урьдчилан сэргийлэх арга хэмжээг Нэгдсэн эмнэлгийн ажилчид, сумдын эрүүл мэндийн ажилчид, эвт

худалдааны төвийн ажилчдад болон ХБИргэдэд сургалт мэдээлэл өгч сургалтын материалыг тарааж ажилласан. Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Хүний эрхийн хороотой хамтарч төрийн байгууллагын ХАБ хариуцсан мэргэжилтнүүдэд иргэдийн танхимд болон халамж үйлчилгээний төвд сургалт зохион байгуулж арга зүйн зөвөлгөө өгч ажилласан.

Эмчлэн эдгэрүүлэх төлөвлөгөө боловсруулж, Сэргээн засах тасгийн эрхлэгч Хатанбаатар эмчтэй хамтран ажиллаж Физик эмчилгээнд илүүтэй хамруулан эмчилгээнд бариа заслаас гадна зүү төөнүүр, хөдөлгөөн засал, татлага эмчилгээний төрлүүдийг нэмэгдүүлж ажилласан нь үр дүнгээ өгч байгаа бөгөөд одоогийн байдлаар 250 гаруй иргэдийг уламжлалт үзлэгт хамруулж 32 иргэнийг хэвтэн эмчлүүлээд байна.

## СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ

### ДОТООДЫН СУРГАЛТ


Тайлант хугацаанд нийгмийн даатгалын чанар хүртээмж, хамралтыг сайжруулах зорилгоор ажил олгогч, даатгуулагч болон ажилтнуудыг мэргэшүүлэх, сургаж дадлагажуулахад анхаарч ажиллаа. Тухайлбал:

- Мэргэшүүлэх сургалтыг дотооддоо Нийгмийн даатгалын ерөнхий газар болон хэлтэс, орон нутгийн байгууллагаас зохион байгуулсан албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх 22 удаагийн цахим болон танхимын сургалтад давхардсан тоогоор 420 албан хаагчдыг хамруулсан.


Үүний дотор: “Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 вебинар” 10 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 210 албан хаагч хамруулсан.



- 2024.01.12 ны өдөр НДЕГ-аас зохион байгуулсан "Цахим мэдээллийн цаг"-ийг "Хүн амын орлогын албан татварын тухай хууль, тайлан гаргахад анхаарах асуудал"-ын талаар сургалтад газрын 26 алба хаагч хамрагдсан.





➤ 2024.01.19 ны өдөр “ХАСХОМ мэдүүлэх нь” сэдэвт сургалтад газрын 26 алба хаагчид бүрэн хамрагдсан.



➤ 2024.01.22 ны өдөр Sicos системийн талаарх сургалтад газрын 26 алба хаагчид бүрэн хамрагдсан.

➤ 2024.02.20 ны өдөр "Ажил олгогчийн тайлангын систем" -ийн танилцуулга сургалтад цахимаар ОШТ-ийн дарга, Орлого шимтгэлийн байцаагч, ХШТ-ийн дарга, Хяналт шалгалтын байцаагч, Үйл ажиллагааны нягтлан, Мэдээллийн технологийн мэргэжилтэн нар хамрагдсан.






➤ ХНХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга танилцуулга сургалтад газрын 25 алба хаагч хамрагдсан.



➤ 2023.03.15-ны өглөө 08:30 цагийн "Мэдээллийн цаг"-аар "Донорын төв"-ийн эмч Алтантулга "Донорын тухай хууль, хуулийн хэрэгжилт", "Оршуулгын тэтгэмж, амьгүй донор менежмент" сэдвээр мэдээлэл өглөө. Тус сураглтад газрын тэтгэмжийн байцаагч болон магадлах эмч нар цахимаар оролцсон.



➤ 2024.04.08 "хөдөлмөрийн аюулгүй байдал- эрүүл ахуйн сарын аян-2024" хүрээнд хийгдэж буй цахим сургалтад тус газрын 27 алба хаагч хамрагдсан.



➤ 2024.04.15 “Цахимд хэвшье “DIGITAL FIRST - 01” Сургалтад тус газрын дарга Н.Нямхатан, МТмэргэжилтэн Б.Баярсайхан нар хамрагдсан.



## ГАДАГШАА ЧИГЭЛСЭН СУРГАЛТ.

➤ Ажил олгогч даатгуулагчдад чиглэсэн сургалтыг оны эхнээс төлөвлөгөө гарган хэлтсийн даргаар батлуулан хагас жилийн байдлаар **49** удаагийн сургалтаар **90** нэгжид буюу **4306** иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт, мэдээлэл хүргэн ажилласан.

➤ ААН албан байгууллага, иргэд даатгуулагчид чиглэсэн сургалтын хүрээнд **14** удаагийн сургалтаар **32** нэгжид сургалт уулзалт хийсэн. **2056** иргэд, даатгуулагчид сургалт, уулзалтад хамрагдаад байна.







➤ Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, иргэд, малчдад чиглэсэн сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх 18 удаагийн сургалтаар 50 нэгжид сургалт хийсэн. 2450 иргэд даатгуулагч сургалтад хамрагдсан




➤ [www.hentii.ndaatgal.mn](http://www.hentii.ndaatgal.mn) вэб сайт, [www.facebook.com/NDKHenti](https://www.facebook.com/NDKHenti) фэйсбүүк, “Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар” фэйж хуудсаар **78** мэдээлэл, постер оруулж мөн ХНХЯам, НДЕГазраас бэлтгэсэн сурталчилгаа, мэдээ, мэдээллийг цахим сүлжээ ашиглан олон нийтэд түгээсэн ба давхардсан тоогоор 98 мянга гаруй иргэд даатгуулагчдад хүрсэн байна.






Нийт албан хаагчид НДЕГ-ын @sigomongolia фэйсбүүк хуудсыг дагаж, мэдээлэл авах, мэдээллийг цааш түгээх ажлыг гарын алба хаагчид болон сумын байцаагчид 31 албан хаагч НДЕГ-ын фэйсбүүк хуудсыг дагаж, мэдээллийг цааш түгээн ажилласан.



- Нийгмийн даатгал “ЦАХИМ ХӨТӨЧТЭЙ”-тэй боллоо. Цахим хөтчийг нэвтрүүлсэн талаар пост мэдээллийг газрын фэйж хуудас болон аймаг сумын группүүдэд мэдээллэж түгээж танилцуулж ажиллаж байна.



**ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР.**